**Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан**
**үндэсний хөгжлийн цогц бодлогын биелэлт-Хэнтий аймаг**

| Заалтын дугаар | Стратегийн зорилт | арга хэмжээний | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн /2015 он/ | Биелэлт | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ***4.5 Эрүүл мэндийн хөгжлийн бодлого*** | | | |
| 4.5.1 | Сум өрхийн эмнэлгийн анхан шатны тусламж хүргэх, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ дархлаажуулалт хийх шүдний өвчин эмчлэх БЗДХ, ХДХВ/ДОХ сүрьеэгээс сэргийлэх, эх нялхасын эрүүл мэндийг хамгаалах чадамжийг цогц байдлаар хөгжүүлнэ | 1. | Эх, нялхасыг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох | НҮЭМэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийн түвшин 1990 онтой харьцуулахад 4 дахин буурсан байна. /100,000 амьд төрөлт тутамд/ | 50 | 100,000 амьд төрөлтөнд ногдох эхийн эндэгдлийн түвшин 1990 онд 199,0 промиль байсан бол нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэхэд анхаарч ажиллан 2010 оны эцсийн байдлаар эхийн эндэгдэл гараагүй. | 50 |
| | | | | Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1990 онтой харьцуулахад 4 дахин буурсан байна. /1000 амьд төрөлт тутамд/ | 21 | 1000 амьд төрөлтөнд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1990 онд 93,1 байсан бол 2010 оны байдлаар 28,1 болж 65,0 промилоор буурсан үзүүлэлттэй байна. | 30 |
| | | | | Нялхасын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/ | 15 | 1000 амьд төрөлтөнд ногдох нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1990 онд 62,2 байсан бол 2010 оны байдлаар 19,5 болж 42,7 промилоор буурсан үзүүлэлттэй байна. | 30 |
| | | 2. | Шүд эмчлэх, эрхтэн тогтолцооны өвчний оношилгоо, эмчилгээний арга, технологийг сумын түвшинд нэвтрүүлэх | Шүд цоорох өвчний тархалтын хувь /5-6 насны хүүхдийн дунд/ | 75 хувь | Хэрлэн сумын 5 цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудын 1-р ангийн сурагчдыг зорилтот бүлэг болгон амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж шүд цоорлтын эрчмийг тогтоосон.<br>5-6 настай хүүхдийн шүд цоорох өвчний тархалтын хувь - 82%. ХЯБхөтөлбөрийн шугамаар 29,8 сая төгрөгийн өртөгтэйгөөр Нэгдсэн эмнэлэгт-1, Тэмүүжин цогцолбор сургуульд 1 нийт 2 | 10 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ш шүдний “Бор” машин олгогдож, сургуулиудыг мэргэжлийн шүдний эмчээр хангах бодлого барьж, Тэмүүжин ЦС-ийг шүдний эмчтэй болгож, Нэгдсэн эмнэлгийн шүдний 2 кабинет, үүдэн эмнэлгүүдэд сургууль, цэцэрлэгийг хувиарлан эрүүлжүүлэх арга хэмжээ авч эхлээд байна. | |
| | | 3. | БЗДХ, ХДХВ/ДОХ, сүрьеэтэй тэмцэх чадвартай болгох | 2015 он гэхэд ХДХВ/ДОХ, сүрьеэ өвчний тархалтыг зогсоож, БЗДХ-ыг бууруулж эхэлсэн байна.<br>-Жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд ХДХВ-ийн тархалт<br>-15-24 насны залуучуудын дундах ХДХВ-ын халдварын тархалт<br>-Сүрьеэ өвчний тархалт /100,000 хүн амд/<br>-Сүрьеэгийн өвчлөлийн түвшин /100000 хүн амд /<br>-Сүрьеэгээс шалтгаалсан нас баралт | <0.1<br><0.1<br>82.0<br>100.0<br>2.0 | Сүрьеэтэй тэмцэх сэргийлэх 2009-2015 он хүртэлх стратеги төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.<br>-Жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд ХДХВ-ийн тархалт - 0<br>-15-24 насны залуучуудын дундах ХДХВ-ын халдварын тархалт - 0<br>- Сүрьеэ өвчний тархалт 14,5<br>- Сүрьеэгийн өвчлөлийн түвшин 80.0<br>- Сүрьеэгээс шалтгаалсан нас баралт - 0 | 10 |
| | | 4. | Малчдад нүүдлийн өрхийн эмнэлгээр үйлчлэх тогтолцоог бүрдүүлэх | Малчдад явуулын амбулаторийн тусламж, үйлчлилгээг үзүүлэх заавар журам батлагдаж, үйл ажиллагаа явагдаж эхэлсэн байна. | Хэрэгжилтийн үр дүнгээр | Дэлгэрхаан, Хэрлэнбаян-Улаан, Цэнхэрмандал, Баянхутаг, Өлзийт зэрэг зудтай сумдын 150 гаруй айл өрхийн хүн амд очиж үзлэг шинжилгээ хийж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. 2010 оны сүүлийн хагас жилд Аймгийн Засаг даргын захирамжаар 2,4 сая төгрөгийн хөрөнгө шийдвэрлүүлэн бүх сумдад “Явуулын амбулатори” ажиллуулан 14000 гаруй иргэдийг үзлэгт хамруулсан. | 10 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.5.2 | Аймаг, дүүргийн болон улсын клиникийн нэгдсэн эмнэлэг, мэргэжлийн төвүүдийн үйл ажиллагаан ы чадамжийг хөгжүүлнэ | 1. | Хорт хавдарыг эрт оношлох, эмчлэх боломжоор аймаг, дүүргийн эмнэлгийг хангах | Хорт хавдарын эрт илрүүлэлт:<br>-I үе<br>-II үе<br>Хорт хавдар нь оношлогдсоноос хойш 5-аас дээш жил амьдарсан хүний эзлэх хувь:<br>-умайн хүзүүний хорт хавдар<br>-хөхний хорт хавдар | 8,0<br>15,3<br><br>35,0<br>31,0 | Хорт хавдрын эрт илрүүлэлтийн байдлыг авч үзвэл:<br>1-р үед нь илрүүлсэн хорт хавдрын эзлэх хувь-2.3,<br>2-р үед нь илрүүлсэн хорт хавдрын эзлэх хувь-39.2 байна.<br><br>Хорт хавдар нь оношлогдсоноос хойш 5-аас дээш жил амьдарсан хүний эзлэх хувь - 11.6<br>- умайн хүзүүний хорт хавдар 18,2%<br>- хөхний хорт хавдар 50% | 10 |
| | | 2. | Алсын зайн оношилгоо, эмчилгээний аргуудыг эмнэлэгт нэвтрүүлэх | Алсын зайн оношилгоо, эмчилгээний аргыг нэвтрүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | 20 | Аймгийн нэгдсэн эмнэлэг нь 2009 оноос алсын зайн оношилгоо, эмчилгээний аргыг нэвтрүүлэн ажиллаж байна. | 30 |
| | | 3. | Өвчний түүхийг цахим картын тогтолцоонд оруулах | Өвчний түүхийг цахим карт нэвтрүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | 8 | УАУТөв нь 2008 оноос өвчний түүхийг цахим картанд шилжүүлэн ажиллаж хэвшүүлсэн нь үр дүнгээ өгч байна. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.5.3 | Эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай боловсон | 1. | Эрүүл мэндийн байгууллагыг үйлчлүүлэгчээ дээдэлсэн үйл ажиллагааны зарчимтай болгох | Эрүүл мэндийн байгууллага, эмч мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний зарчмыг мөрдлөг болгон ажилласан байна. | Хэрэгжилтийн үр дүнгээр | **1.Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр**: ЭМГ-ын дэргэдэх ёс зүйн салбар хорооны 2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 10 зүйлтэйгээр гарган хэрэгжүүлэн ажиллаж ирлээ. Үүнд: Салбар хорооны хурлыг 10 удаа хуралдуулж асуудлуудыг шийдвэрлэн, ёс зүйн чиглэлээр 4 удаа сургалт зохион байгуулж, 383 мэргэжилтнийг хамруулсан. ЭМБ-дад ёс зүйн багуудыг байгууллагын даргын тушаалаар ажиллуулснаар дотооддоо асуудлаа шийдвэрлэн ажиллаж ирлээ. ЭМГ-т хуулийн зөвлөхийг гэрээгээр ажиллуулж 5 асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа авлаа. ЭМГ-ын дэргэдэх ёс зүйн салбар хорооны хурлаар эвлэрүүлэн зуучлагчаар ажиллуулах мэргэжилтнийг сонгон сургалтанд хамруууллаа. Үйлчлүүлэгчийн эрх, үүргийн талаар нийтэд харагдахуйц газар самбар байрлуулан таниулах ажлыг нэгдсэн эмнэлэг, өрх, сумын эмнэлгүүдэд зохион байгуулсан. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулж ЭМГ-ын мэргэжилтнүүд албан байгууллага, ард иргэдэд мэдээлэл хийсэн. Ёс зүйн салбар хорооны гишүүд нэгдсэн эмнэлэг сум, өрхийн эмнэлгүүдэд ажиллахдаа үйлчлүүлэгч нартай уулзаж асуудлыг шийдвэрлэж ажилласан. Аймгийн нэгдсэн эмнэлгийн эмчилгээний чанарын хяналтын менежерийг нэгдсэн эмнэлэгт эвлэрүүлэн зуучлагчаар ажиллуулж өргөдөл гомдол,санал хүсэлтийг шийдвэрлэж ажилласан.<br>Ёс зүйгээр манлайлагч эрүүл мэндийн ажилтан шалгаруулах болзол гаргаж ЭМБ-уудаас ирүүлсэн хамт олны хурлын протоколыг ёс зүйн салбар хорооны хурлаар хэлэлцүүлэхэд НЭ-ийн мэдрэлийн их эмч О.Намжилмаа шалгарлаа.<br><br>**2. Хариуцлагыг сайжруулж, ил тод байдлыг хангах чиглэлээр:**<br><br>Үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг 4 удаа авч ЭМБ-уудад санал хүсэлтийн хайрцаг ажиллуулсан. Ёс зүйн салбар хорооны хурлаар 7 эмч, 1 тусгай мэргэжилтэн, 1 эмнэлгийн хамт олонтой холбогдолтой ирүүлсэн иргэний гомдол, аймгийн мэргэжлийн хяналтын газрын эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг хэлэлцэн ёс зүйн салбар хорооны эрхийн хэмжээнд арга хэмжээ тооцон ажилласан.<br>ЭМБ-дын дотоод журмыг хамт олны хурлаар хэлэлцүүлэн батлуулж мөрдлөг болгон ажиллаж | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.5.4 | Хүн амын өвчлөл, цаг бусын нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг ахиулна. Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлнэ. | 1. | Хүн амд амьдралын зөв зохистой хэвшил, бие бялдараа чийрэгжүүлэх орчин бүрдүүлэх | Зөв хооллох, дасгал хөдөлгөөний дэмжих бодлогын баримт бичигтэй болсон байна.<br>Илүүдэл жинтэй ба таргалалттай хүн амын эзлэх хувь<br>Хөдөлгөөний хомсдолтой хүн амын эзлэх хувь | 30,0 хувь<br><br>20,0 хувь | Орон нутагт нийгмийн эрүүл мэндийн төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. ЗГ-ын 224-р тогтоолын сэдэвчилсэн төлөвлөгөөний дагуу аймгийн хүн амын дунд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх ажлуудыг зохион байгуулж байна. Ялангуяа бага наснаас нь эхлэн эрүүл амьдралын хэв маягийг эзэмшүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна. | 50 |
| | | 2. | Хүн амын дунд эрүүл аж төрөх, уур амьсгалын дарамт, удамшлын аливаа доголдлоос эрүүл мэндээ хамгаалахад чиглэсэн сургалт, сурталчилгааг өргөжүүлэх | Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны бодлогын баримт бичигтэй болж, мөрдөж эхэлсэн байна. | Хэрэгжилтийн үр дүнгээр | “Хүүхдийн эрүүл мэндийн дэд хөтөлбөр” боловсруулан Хэрлэн сумын ИТХурлаар хэлэлцүүлж батлуулан Хэрлэн сумын ЕБС-иудын 6 настай сурагчдыг хараа, сонсгол, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт, хамруулан, өвчлөлийг тодорхойлохын хамт аливаа өвчнөөс сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэх ажлууд хүүхдийн байгууллагуудын дунд үе шаттай хийгдэж байна. ММССангаас зарлагдсан жижиг тэтгэлэгт уралдаанд ЭМГ-ын НЭМАлба нь 2, Бор-Өндөр тосгоны НЭ-ийн 1 төсөл шалгарсан. Эдгээр төслийн хүрээнд зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах талаар зорилтот бүлгийн хүн амд сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах юм. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3. | Нөхөн сэргээх, асаргаа, сувилгааны төрлүүдийг хөгжүүлэх | Нөхөн сэргээх, асаргаа, сувилгааны бодлогын баримт бичигтэй болсон байна.<br>Нөхөн сэргээх, асаргаа сувилгааны чиглэлээр боловсруулан оношилгоо, эмчилгээний удирдамжийн тоо | Хэрэгжилтийн үр дүнгээр | Нэгдсэн эмнэлгийн сэргээн засах эмчилгээний кабинетийг өргөжүүлэн 6 ортой эмчилгээний тасгийг нэмж ажиллуулан эмийн бус эмчилгээг түлхүү хэрэглэдэг болсон. ЭМСайдын 2004 оны “Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, асаргаа сувилгаа хийх журмыг мөрдөн ажиллаж байна. Үүнд ЭМГ-аас жилдээ 2 удаа гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээг хавдартай болон гэрийн асаргаанд байгаа хүмүүсийн дунд зохион байгуулж хэвшсэн нь үр дүнтэй ажлын нэг болоод байна. | 10 |
| | | 4. | Уламжлалт анагаах ухааны шилдэг аргыг эрүүл мэндийн үйлчилгээнд нэвтрүүлэх | Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх бодлогын баримт бичигтэй болсон байна. | Хэрэгжилтийн үр дүнгээр | Япон улсын санхүүжилтээр хэрэгжиж буй “Уламжлалт анагаах ухааныг дэлгэрүүлэх нь” Вамсэмбэрүү төсөл 2006 оноос Өмнөдэлгэр, Мөрөн суманд үр дүнтэй хэрэгжиж байгаа бөгөөд 2010 оноос Баянмөнх, Дархан, Хэрлэн суманд хэрэгжиж байна. Энэ төсөл нь өрхийн анхан шатны тусламжинд шаардагдах уламжлалт эмийг өрхүүдэд хүргэх эрүүл мэндийн үйлчилгээг нэвтрүүлэх юм. | 30 |
| | | 5. | Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын асуудлыг шийдвэрлэх эрсдлийн менежментийн чадавхийг бэхжүүлэх | Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын асуудлыг шийдвэрлэх эрсдлийн менежментийн чадавхийг бэхжүүлэх сургалтын тоо | Хэрэгжилтийн үр дүнгээр | Аймгийн Онцгой байдлын газар, БГХӨСТөв, ЭМГазар хамтран бүх сумдад команд штабын сургалт, үзүүлэх сургууль зохион байгуулан бэлэн байдлыг газар дээр нь шалгаж үүрэгжүүлэн ажилласан. ХБУлаан, Биндэр, Өмнөдэлгэр сумдад Гамшгаас хамгаалах, иж бүрэн сургалтыг тарваган тахал, боом, шүлхий, шувууны томуу өвчнөөр цагийн байдал өгч дадлага сургалт зохион байгуулав. Мөн Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг Бор-Өндөр, Бэрх, Баян-Адарга, Батширээт сумдад гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургалтыг зохион байгуулсан. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 6. | Сум, дүүрэг, хот суурин газар болон гэр бүл, ажлын байранд эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх | Сум, дүүрэг, хот суурин газар болон ажлын байранд эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх бодлогын баримт бичигтэй болсон байна.<br>Эрүүл мэндийг дэмжигч:<br>-өрх<br>-сургууль, цэцэрлэг<br>-байгууллагын тоо | Хэрэгжилтийн үр дүнгээр | ЭМСайдын 85-р тушаалын дагуу орон нутагт "Эрүүл мэндийг дэмжигч" байгууллага, хамт олон, өрх шалгаруулах уралдааныг 3 сарын хугацаатай зарлаад байна. Одоогоор Хэрлэн сумын 8 албан байгууллага, аж ахуйн нэгжүүд эрүүл мэндийг дэмжих загвар байгууллага болохоор ажиллаж байгаа ба эдгээрт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтарч ажиллаж байна.<br>Хэрлэн сумын ЗДТГ-тай хамтарч Эрүүл хот болох ажлыг эхлүүлээд байна | 30 |
| | | 7. | Хүн амыг баталгаат ундны усаар хангах, эрүүл ахуйг сайжруулах, химийн болон бусад үйлдвэр, ахуйн хог хаягдлын менежментийг багтаасан амьдралын эрүүл орчин бий болгох замаар эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх | Хүн амыг баталгаат ундны усаар хангах, эрүүл ахуйг сайжруулах, химийн болон бусад үйлдвэр, ахуйн хог хаягдлын менежментийг сайжруулах бодлогын баримт бичигтэй болж мөрдлөг болсон байна.<br>Гэдэсний халдварт өвчин /10000 хүн амд/:<br>-Балнад<br>-Сальмонеллез<br>-Цусан суулга<br>-Гепатит А<br>Амьсгалын дээд замын үрэвсэлт өвчин /10000 хүн амд/<br>-Цочмог төвөнхөс, мөгөөрсөн хоолойтос<br>-Гуурсан хоолойн багтраа | Хэрэгжилтийн үр дүнгээр | Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын менежментийг сайжруулах талаар “Файр” ТББ-тай хамтран төсөл хэрэгжүүлж сум, өрх, НЭ-ийн 2 жилийн хэрэгцээний аюулгүйн хайрцгаар хангасан.<br><br>Гэдэсний халдварт өвчин /10000 хүн амд/:<br><br>- Балнад-0<br>- Сальмонеллез-0<br>- Цусан суулга- 5,85<br>- Гепатит А -32,3<br>Амьсгалын дээд замын үрэвсэлт өвчин / 10000 хүн амд/-455,4<br><br>-Цочмог төвөнхөс, мөгөөрсөн хоолойтос -62,6<br><br>-Гуурсан хоолойн багтраа 6,8 | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.5.6 | Хүн амыг аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр ханган эрүүл мэндийн шаардлагатай, зохистой технологийг нэвтрүүлж, салбарын дэд бүтцийг сайжруулна | 1 | Хүн амыг зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр жигд, хүртээмжтэй, тасралтгүй хангах | Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн хувь | Хэрэгжилтийн үр дүнгээр | Хүн амыг зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр жигд, хүртээмжтэй, тасралтгүй хангах зорилгоор:<br>-Аймгийн төвд Монос, Оол эм ХХК-ны эмийн бөөний төвүүдэд тусгай зөвшөөрөл олгосон нь үр дүнтэй ажил боллоо.<br>- Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн хувь 79,2 | 30 |
| | | 2 | Хүн ам, эрүүл мэндийн байгууллагад эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх | Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх бодлогын баримт бичгийн тоо<br>Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй нэг өвчтөнд хэрэглэсэн эмийн нэр төрөл | Хэрэгжилтийн үр дүнгээр | Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалтыг төв хөдөөгийн 55 эмч мэргэжилтнүүдэд зохион байгуулав.<br><br>Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй нэг өвчтөнд хэрэглэсэн эмийн нэр төрлийн тоо 5-6 | 30 |
| | | 3 | Эмнэлэг, лабораторийн тоног төхөөрөмжийн байнгын нийлүүлэлт, засвар үйлчилгээг хангах тогтолцоо бий болгож, оношилгооны чадавхийг сайжруулах | Лабораторийн чанарын хяналтын тогтолцоо бүрэн нэвтэрсэн байна. 1.5 % | 10 хувь | Бүх сумдын эмнэлэгүүд лабораторийн тоног төхөөрөмжөөр хангагдаж 21 сумын эмнэлгийн лаборант нарыг сургаж бэлтгэсэн. Аймгийн нэгдсэн эмнэлэгийн лабораторийн тоног төхөөрөмжийн нийлүүлэлт нэмэгдэж, 2010 оноос тоног төхөөрөмжийн мэргэжилтэн ажиллуулж засвар үйлчилгээг тогтмолжуулснаар оношилгооны чадавхийг бэхжүүлэхэд тодорхой үр дүн өгч байна. | 50 |
| ***3.2.3 Боловсролын хөгжил*** | | | | | | | |
| 3.2.3 | Багшийн мэргэжил, аргазүйн хөгжил болон цалин хөлс, урамшуулал, нийгмийн асуудлыг | 1. | *Багш боловсролын байгууллагын удирдах ажилтны ур чадварыг хөгжүүлж, ажлын чанар, хөдөлмөрийн үр бүтээлийг үнэлэх* | Мэргэшил дээшлүүлэхэд зарцуулсан нийт зардлын хэмжээ /**200 сая төгрөг**/ жилд/ | 50 | Төсвөөс багшийн мэргэжил дээшлүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ буурч байна. 2007-2009 онд нийтдээ 545,5 сая төгрөгийн зарцуулсан байна.<br>Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг бодит эрэлт хэрэгцээнд тулгуурлан нягтлан үзэх шаардлагатай. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цогцоор нь шийдвэрлэж, энэ чиглэлд хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлнэ. | | *шалгууруудыг зөв тогтоож, цалин хөлс нэмэгдүүлэх, урамшуулал олгох зэргээр нийгмийн хамгааллыг сайжруулах* | | | | |
| | Боловсролын бүх түвшний стандарт, сургалтын хөтөлбөрийг тухайн үеийн суралцагчийн хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн боловсронгүй болгоно. | 2. | Шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан болосролын стандартын шалгууруудыг нарийвчлан тогтоож, бүх түвшний сургуулиудыг олон улсын боловсролын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөтэй болгох | Стандартын шалгуур хангасан хөтөлбөрийн хувь **-30%** | 0 хувь | Боловсролын бүх түвшний стандарт, түүнийг хангасан хөтөлбөрийг тодорхойлох боломжгүй тул шалгуур үзүүлэлтийг дахин нягтлах шаардлагатай. | 0 |
| ***3.2.4 Соёлын хөгжил*** Удирдлага | | | | | | | |
| 3.2.4 | Үндэсний соёлыг эрчимтэй хөгжүүлэх эдийн засаг, зохион байгуулалтын тааламжтай орчинг бүрдүүлнэ. | 1. | Соёлын удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт зах зээлийн эдийн засгийн горимд шилжих үйл явцыг түргэтгэж, салбарын бүх шатанд мэргэжлийн ба удирдлагын ур чадварыг дээшлүүлэх | Жилд мэргэшил дээшлүүлсэн ажилтны хувь**-25%** | 100 хувь | 2007 онд 30 %<br>2008 онд 35 %<br>2009 онд 50 %<br>2010 онд 70 % | 30 |
| | Хүн амд | 2. | Монгол Улсын | Улсын нэгдсэн бүртгэл | 100 | Аймгийн музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | соёл, урлагийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж, иргэдийн оюуны хэрэгцээг хангах талаар дорвитой ахиц гаргана. | | үндэстэн, ястан, үндэсний цөөнхий болон хүн амын янз бүрийн давхрагуудын оюуны хэрэгцээг үе шаттай судлан тодорхойлож, тэдгээрт тохирсон соёл, урлагийн үйлчилгээний төрөл, үр ашигтай арга хэлбэрээр сонгож хэрэглэх | мэдээллийн санд явуулсан үзмэрийн тоо | хувь | нийт 1614ш үзмэрийн бүртгэлийг СӨТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хүргэгдсэн. | |

| 3.2.6.Нийгмийн хамгаалал | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Иргэний хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүтээмж, ур чадварыг хөгжүүлэх үндсэн дээр цалин хөлсийг нэмэгдүүлэх, бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн түншлэлийг төлөвшүүлэх эд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг, оновчтой үр ашигтай болгож, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинг сайжруулах, олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх замаар эрх зүйн орчныг боловсронгуй болгож цалин хөлсийг нэмэгдүүлэх | Нийгмийн халамж хүртэгсдийн мэдээллийн санг бүрдүүлсэн байна. | | Нийгмийн халамж хүртэгсдийн мэдээллийн санд Хэнтий аймгийн хэмжээнд 2010 оны байдлаар 23.8 мянган иргэн бүртгэлтэй байна. | 30 |
| | | | | Гадаадад ажиллах хүч гаргах, авах бодлого, эрх зүйн орчинг шинэчилсэн байна | | Өлзийт, Баянхутаг, Бор-Өндөр, Цэнхэрмандал, Галшар зэрэг сум,тосгонд зөвшөөрөлтэй 8 гадаадын иргэн ажиллаж байна. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| *4.2.1.1. Хувийн секторын хөгжил ба жижиг дунд үйлдвэрлэл* | | | | | | | |
| | Бизнесийн орчинг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. Хувийн хэвшил, Засгийн газрын байгууллагуудын түншлэлийг дэмжин хөгжүүлж,бэхжүүлнэ. | | Засгийн газар хувийн хэвшил хоорондын зөвлөлдөх хорооны үйл ажиллагааг идэвхжүүлж, тогтмолжуулах механизмыг төлөвшүүлж, хувийн хэвшлийн үйл ажллагааг ил тод, шудрага явагдах нөхцөлийг бүрдүүлэх | Мэргэжлийн холбоод болон ТББ-тай хамтран шийдвэрлэсэн асуудал - Төрийн байгууллага болон мэргэжлийн холбоод, ТББ-тай хамтран ажиллана | | *Хэнтий аймгийн ЗДТГ, аймгийн ҮЭХороо, аймгийн Ажил олгогч эздийн холбоо хамтарсан 2010-2011 оны Нийгмийн зөвшилийн 3 талт хэлэлцээрийг 2010 оны 3 дугаар сард байгуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.* | 30 |
| 4.2.2.4. Хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэл | | | | | | | |
| | Бүс нутгийн онцлогийг харгалзан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, халдварт өвчний гаралт, тархалтыг эрс бууруулан | | ***Монгол малын тэсвэрт чанарыг бататган, цус ойртохоос урьдчилан сэргийлж, биологийн боломжийг бүрэн ашиглаж, байгалийн эрсдэл даах чадварыг нь бэхжүүлэх*** | Цөм сүргийн малын тоо 2008 онтой харьцуулахад 10 хувиар өссөн байна (ШҮ- Цөм сүргийн малын тооны өсөлт) | | Аймгийн хэмжээнд нийт малын тоо 70.4 мянган толгойгоор буурсан нь өмнөх жилүүдийн зудын байдалтай холбоотой юм. Цөм сүргийн тоо өмнөх оныхоос 2000 гаруй толгойгоор өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь сум бүрт цөм сүрэг бүхий өрх айл бий болсонтой холбоотой юм. Цаашид цөм сүрэг бүхий өрхүүдэд үржүүлэгдэж буй хээлтэгчийн тоог нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна. | 30 |
| | | | | Мал үржүүлгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэн биотехнологийн үйлдвэрлэлийн ололтыг нэвтрүүлсэн байна | | Аймгийн хэмжээнд зохиомол хээлтүүлгийн 6 цэг ажиллаж байгаа бөгөөд энэ онд ХЯБХ –ийн хөрөнгөөр Дадал суманд явуулын 1 цэг шинээр байгуулаад байна. 187 үнээ, 1500 эм хонинд зохиомол хээлтүүлэг хийлээ. Мах-ноосны чиглэлийн ТНЦ үүлдрийн хонины удмын санг хамгаалах зорилгоор уг хониос үр авч удмын сангийн үндэсний төвд хадгалуулах ажлыг зохион байгууллаа. Цөм сүрэг бүхий өрхүүдээс 500 гаруй толгой өсвөр хээлтүүлэгч бойжуулаад байна. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | малыг эрүүлжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, экспортыг нэмэгдүүлнэ. | | "Тэжээл" хөтөлбөр хэрэгжүүлж, малын тэжээл, усны хангамжийг сайжруулах | Малын тэжээл" хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрэх үр дүнгээр | | ХХААХҮЯамтай хамтран 6.0 тонн хөх тариа, 1.0 тонн овъёос, 0.3 тонн царгасыг малын тэжээл тариалах сонирхол бүхий иргэд, аж ахуй нэгжид гэрээгээр олгосон ба Хэрлэнбаян-Улаан тосгонд 20 га газар, Норовлин суманд 10 –га газар, Хэрлэн сумын иргэн Гансүх -1,5 га газар эрдэнэ шиш, манжин, " Хэнтий сүү " хоршоо 10 –га газар хөх тариа тариалж малын дарш, тэжээлийг бэлтгэлээ. 2010 онд аймгийн хэмжээнд малын тэжээл 458.6 га, овъёос 482 га-д нийт 3 аж ахуйн нэгж, нэг хоршоо, 3 иргэн тариалж, 1815 тонн малын тэжээл хурааж авсан. Мөн Хэрлэн сумын "Өндөрхаан" ХК Өмнөдэлгэр суманд тэжээлийн цех байгуулах зорилгоор ЖДҮ-ийг дэмжих дэд сангаас 50.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, ХЯБХөтөлбөрийн дэмжлэгээр аймгийн төвд жижиг оврын тэжээлийн цех байгуулагдан ажиллаж байна. | 50 |
| | | | Малын тэжээлийн үйлдвэрлэл, нийлүүлэлт, хэрэглээний эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, төрийн бодлогоор дэмжих | 700 тн тэжээл үйлдвэрлэж, 30 тэжээлийн үйлдвэртэй болно (ШҮ- Тэжээлийн үйлдвэрийн тоо, үйлдвэрлэсэн тэжээлийн хэмжээ) | | Аймгийн хэмжээнд энэ онд 125 мянган тонн байгалийн хадлан, 210 тонн ногоон тэжээл, 450 тонн үйлдвэрийн тэжээл, 100 тонн гар тэжээл бэлтгэхээр төлөвлөж, уг ажилд 1278 техник хэрэгсэл, 3007 хүн хүч гарч, 127.8 мянган тонн байгалийн хадлан, 1889.3 тонн ногоон тэжээл, 458.5 тонн үйлдвэрийн тэжээл, 131.9 тонн гар тэжээл тус тус бэлтгэсэн ба төлөвлөгөөт өвсийг 102.2%, ногоон тэжээлийг 9 дахин, үйлдвэрийн тэжээлийг 101.8%, гар тэжээлийг 131.9% давуулан биелүүлээд байна. Мөн аймгийн Засаг даргын нөөцөд 225 тонн өвс, 350 тонн тэжээл, сумын аюулгүйн нөөцөд 1739 тонн өвс тус тус бэлтгэлээ. Өмнөх онтой харьцуулахад хадлан 36599тн, гар тэжээл 27,9тн-оор нэмж бэлтгэсэн байна.<br>Аймгийн Засаг даргын нөөцөд 1964 тонн өвс, 350 тонн тэжээлийн нөөцийг бүрдүүлсэн. Сумын нөөц бүрдүүлэхэд орон нутгийн нөөцөөс сум бүрт 2,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр сум тус бүр 100 тн өвсийг нөөцлөөд байна. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шимт чанар сайтай, ургац ихтэй тэжээлийн шинэ төрлийн таримал нутагшуулах, үр үйлдвэрийг дэмжиж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, фермерийн аж ахуйг тэжээлийн ургамлын үрээр хангах тогтолцоог бүрдүүлэх | 1200,0 мян.тн байгалийн хадлан бэлтгэж аливаа эрсдлээс хамгаалагдана (ШҮ-Бэлчээр хадлангийн талбайг хамгаалах, сайжруулах хадлан тэжээл бэлтгэх чиглэлээр дэмжлэг авсан иргэд, аж ахуйн нэгжийн тоо) | | Аймгийн хэмжээнд энэ онд 125 мянган тонн байгалийн хадлан, 210 тонн ногоон тэжээл, 450 тонн үйлдвэрийн тэжээл, 100 тонн гар тэжээл бэлтгэхээр төлөвлөж, уг ажилд 1278 техник хэрэгсэл, 3007 хүн хүч гарч, 127.8 мянган тонн байгалийн хадлан, 1889.3 тонн ногоон тэжээл, 458.5 тонн үйлдвэрийн тэжээл, 131.9 тонн гар тэжээл тус тус бэлтгэсэн ба төлөвлөгөөт өвсийг 102.2%, ногоон тэжээлийг 9 дахин, үйлдвэрийн тэжээлийг 101.8%, гар тэжээлийг 131.9% давуулан биелүүлсэн. | 30 |
| | | | Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар багтаамж, даацыг нэмэгдүүлэн мал аж ахуйн эрсдэлийг бууруулах | Бэлчээрийн даац багтаамжийг шинэчлэн тогтоосон байна | | Бэлчээр ашиглалтын эрхзүйн орчин бүрдээгүй.<br>Бэлчээрийн даац, багтаамжийг тогтоох аргачлал шинэчлэгдэн боловсруулагдаагүй тул монгол орны бэлчээрийн нөөц, даац ямар түвшинд байгаа талаар нэгдсэн судалгааны дүн байхгүй. | 0 |
| | | | | Аймаг дундын отрын бүс нутагт нийт бэлчээрийн 5 орчим хувийг хамгаалах, аймаг сум бүрт өвс тэжээлийн нөөцийн сан, тэжээлийн 150 цех бий болсон байна | | Хэрлэнбаян-Улаан тосгоны нутгийг тусгай хэрэгцээний газарт авч чиг үүрэг бүхий Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааг байгуулан 2007 оны 09 дүгээр сараас эхлэн ажиллуулж байна<br>2010 оны 6 дугаар сараас тал хээрийн цөлжилт ихээр явагдаж, бэлчээрийн талхдалд ороод байгаа Галшар, Баянмөнх, Дархан, Баянхутаг сумдад идлэг шонхор шувууны 1000 хиймэл үүрийг шинээр байгуулсан бөгөөд уг арга хэмжээ нь хөтөлбөрийн хүрээнд идлэг шонхор шувууг хамгаалах, өсгөж үржүүлэхэд чухал нөлөө үзүүлэхийн зэрэгцээ бэлчээрийн талхдалыг биологийн аргаар бууруулахад онцгой ач холбогдолтой юм.<br>Өмнөдэлгэр сумын “Өндөрхаан”ХК, аймгийн ОБГазарт 1,5-3,0 тн/цаг хорголжин болон багсармал холимог тэжээл үйлдвэрлэх хүчин чадал бүхий 2 ш тэжээлийн цехийг суурилуулан ажиллуулж байна. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 4500 инженерийн хийцтэй худаг, гар худаг 1500 гаргасан байна (ШҮ- Малын усан хангамжийн өсөлтийн хувь, Хур борооны усыг хуримтлуулж байгуулсан хөв цөөрмийн тоо) | | 2010 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 135 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр “Буян-Уул”ХХК нь Галшар, Баянхутаг, Баянмөнх, Дархан, Дэлгэрхаан, Баян-Адарга, Норовлин, Баян-Овоо, Батноров, Хэрлэн сумдад инженерийн хийцтэй 10 худаг, ХЯБХөтөлбөрийн хөрөнгөөр 11 худаг тус тус шинээр гаргалаа. Мөн 2010 онд 29, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр 21 энгийн уурхайн худаг гарган ашиглаж байна. Мөн “Энгийн уурхайн худаг гаргах тухай” гарын авлага зөвлөмжийг боловсруулан бүх сумдад хүргүүлж ажилласан 2010 онд нийт 2 нуур, 17 булгийн эхийг хашиж, хамгаалж, тохижуулаад байна. | 50 |
| | | | | Малчдын ундны усны чанарыг нэмэгдүүлэн худгийн ашиглалтыг сайжруулан орчин үеийн ус цэвэршүүлэх арга ажиллагаанд сургасан байна (ШҮ- Худгийн тоо) | | 2010 онд ХХААХҮСайдтай аймгийн Засаг даргын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд 80 уст цэгт хайгуулын ажил хийгдэхээр тусгагдсанаар 7 сараас эхлэн 80 уст цэгт усны хайгуул судалгааны ажлыг "Ус амьдрал" ХХК хийж гүйцэтгэсэн. | 50 |
| | | | | 15.0 сая шоометр усны нөөц бүхий усан сантай боомтууд хөв, цөөрөм баригдана (ШҮ- Шинээр байгуулагдсан зориулалтын гидротехникийн байгууламжийн тоо, хуримтлуулсан усны хэмжээ /мян.шоометр/) | | Улсын төсвийн хөрөнгөөр Цэнхэрмандал сумын Түлүүгийн булан хэмээх газар 150,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 118,3 мянган м3 үер, цас, борооны ус цуглуулах 650 м далан бүхий хөв цөөрмийн байгууламж баригдан ашиглалтад ороод байна. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Малчдыг хөгжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх болон мал аж ахуй эрхлэх арга ухааны чиглэлээр малчдын дунд албан бус сургалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх | Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг батлуулж хэрэгжүүлэх эхний үе шатны төлөвлөгөөг Засгийн газраар батлуулсан байх<br>МАА-н үйлдвэрлэлд залуу малчдыг дадлагажуулах сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, бизнес инкубаци үйлчилгээ үзүүлэх, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ. Нийт сумдын 70 хувьд нь нэвтрүүлэх нэгж бий болсон байх | | “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд 2010-2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран ажиллах 12 байгууллагаас санал авч уулзаж ярилцан аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн өргөтгөсөн хурал, ИТХТэргүүлэгчдийн хурлаар тус тус хэлэлцүүлэн боловсруулж, аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2010 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 40 тоот тогтоол гаргуулж ажиллалаа. Төлөвлөгөөг малчдын аж ахуй эрхлэх, зохион байгуулалтыг сайжруулах, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, үйлдвэрлэлийн бүтээмж, чанар, үр ашгийг дэмжих, малчдын ая тухтай ажиллах, амьдрах нөхцлийг бүрдүүлэх, өөрийгөө удирдах, боловсрол мэдлэгийг дээшлүүлэх талаар гэсэн 5 бүлэг, 36 заалттай боловсруулж, малчдын талаарх суурь судалгаа, өнөөгийн байдал, төрийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулж хийсэн болно.<br>Аймгийн “Залуу малчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж 200 малчин залууст мэдээлэл өгсөн. Мөн 5 сумын “Малчдын зөвлөгөөн”-д оролцож дэлгэрэнгүй мэдээлэл өгч, сурталчилж ажилласан. Аймгийн МАА-н мэргэжилтнүүдийн зөвлөгөөн болон сумдад үйл ажиллагаа явуулж буй МЭҮААНэгжийн захирал ээд, сумдын ЗДТГазрын дарга нарт бүрэн эхээр нь мэдээлж ажиллалаа. Сум бүр багийн хурал, өдөрлөг зохион байгуулж малчдад мэдээлсэн. Малчдад чиглэсэн сургалтуудыг давхардсан тоогоор 22 удаа хийж 947 малчинд 1314 ширхэг гарын авлага материал тарааж хүргүүлсэн байна.<br>Сум бүр багийн өдөрлөг хийж аймгийн хэмжээнд нийт 8000 гаруй малчдад сургалт мэдээлэл хийсэн.<br>“Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”-ийн хүрээнд аймгийн Засаг даргын 210 тоот захирамжаар салбар зөвлөл болон 11 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. 2009 онд ЖДҮ-ийг дэмжих дэд сангаас хоршооны чиглэлээр 2 хоршоонд 17 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдлоо | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Газар тариалан фермерийн аж ахуй эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжүүд зээлийн дэмжлэг үзүүлэх | | Газар тариалан эрхлэгч ААН, иргэнд эзэмшүүлэх талбайн хэмжээг нэмэгдүүлснээр тодорхой хэмжээний зээлд хамрагдах боломжтой болсон.<br>Үүний дагуу 2008 онд тариалангийн аж ахуйн нэгжүүдэд 1.0 тэрбум төгрөгийн итгэлийн зээл олгосон<br>Шалгуур үзүүлэлтийг нарийвчлах шаардлагатай. | 50 |
| | | | Хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа газрыг өмчлүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох эрчимжсэн газар тариалангийн чиглэлээр хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагыг төсөв, татварын бодлогоор дэмжих | Байгалийн аливаа эрсдэлээс хамгаалагдсан хөдөөд тухтай ажиллаж амьдрах нөхцөл бүрдсэнээр хөдөөд ажиллаж амьдрах хүмүүсийн сонирхол нэмэгдэн төвлөрөл саарна | | Газар тариалангийн хөгжлийг хүн амын төвлөрлийн асуудалтай шууд холбох боломжгүй тул үнэлгээ өгөх боломжгүй юм. | 30 |
| | | | | Өрхийн аж ахуйд ашиглах бага оврын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамж нэмэгдсэн байна | | Газар тариалангийн зүтгэх хүчний тракторын 25%, үр тариа хураах комбайны 05%, чиргүүл дүүжин машины 15%-ийг 2008-2010 онуудад шинэчилсэн.<br>Нийт 3 суманд төмс, хүнсний ногооны техникээр үйлчилгээ үзүүлэх дундын нэгж байгуулсан.<br>6 өрхийн АА эрхлэгчдэд төмс, хүнсний ногооны иж бүрдэл олгосон<br>Суурь үзүүлэлт байхгүйгээс гадна зорилтот түвшин тодорхойгүй байна. | 10 |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг хадгалах, чийгийн ууршилтыг багасгахад чиглэсэн дэвшилтэт технологийг газар тариаланд нэвтрүүлнэ</td>
<td>Усалгаатай талбайн хэмжээг 1,0 мянган га-д хүргэнэ</td>
<td></td>
<td>
<table>
<tr><th></th><th>2006</th><th>2007</th><th>2008</th><th>2009</th><th>2010</th></tr>
<tr><td>Усалгаатай талбайн хэмжээ нэмэгдсэн байдлаар /мян.га/*</td><td>19.3</td><td>25.4</td><td>29.6</td><td>31.1</td><td>42.0</td></tr>
<tr><td>Жилд нэмэгдсэн талбай /мян.га/</td><td></td><td>6.6</td><td>4.2</td><td>1.5</td><td>10.9</td></tr>
<tr><td>Усалгаатай тариалсан талбай /мян.га/**</td><td></td><td>20.4</td><td>24.4</td><td>29.4</td><td>31.4</td></tr>
<tr><td>Жилд шинээр барьсан ба засварласан талбай /мян.га/**</td><td></td><td>5.2</td><td>8.04</td><td>6.2</td><td>3.3</td></tr>
</table>
</td>
<td>30</td>
</tr>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>Газар тариалангийн хөгжилд биотехнологи нэвтрүүлэн газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ</td>
<td>Үрсэлгээ бойжуулах төрөлжсөн мэргэжлийн аж ахуй байгуулагдана</td>
<td></td>
<td>Бүх сумдад Агропарк байгуулахаар шийдвэрлэж 30 тонныг багтаамжтай зоорь, 6х20 метрийн харьцаатай хүлэмж, бага оврын тракторын иж бүрдэл олгоход 142,5 сая төгрөг зарцуулсан.</td>
<td>30</td>
</tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ***Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг хадгалах, чийгийн ууршилтыг багасгахад чиглэсэн дэвшилтэт технологийг газар тариаланд нэвтрүүлнэ*** | Эдийн засаг үр ашиг, хөрсний эвдрэлийн хувь | | Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг нэмэгдүүлэх, чийгийн ууршилтыг багасгахад чиглэгдсэн нэг явалтаар 3-5 ба түүнээс илүү агротехникийн үйлдлийг гүйцэтгэх технологийн чадвартай сийрүүлэгүүр, урлуур, комбайн, гербицид шүршигч зэрэг нийт 30 ш техникийг 2009, 2010 онд худалдан авч, жил бүр ургамал хамгааллын бодис ба бордоог 90% хүртэл хөнгөлөлттэй үнээр мөн шатахууныг 30 %-ийн хөнгөлөлтөд аж ахуйн нэгжүүд хамрагдсан байна. Химийн уринш хийх, гербицид цацах төхөөрөмжийг 5 –ыг ААН, иргэний хүсэлтийг үндэслэн ХХААХҮЯ-наас олгуулсан<br>Үтрэмийн аж ахуйд техникийн шинэчлэлийг хийж үр цэвэрлэх болон ачих машин 4 ш, технологийн дэвшилд нийцсэн агуулах барьж ашиглалтад оруулах зорилгоор 100 тонны багтаамжтай 2 ширхэг босоо төмөр агуулахыг Алтан Хурх, Агро-Импекс ХХК-дад олгосон | 30 |

<table>
<tr>
<td></td>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2"></td>
<td>Экологийн цэвэр бүтээгдэхүүний болон импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх</td>
<td>Үйлдвэрлэсэн экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээ</td>
<td></td>
<td>Экологийн цэвэр бүтээгдэхүүн (2006-2015), Иод дутлын эмгэгтэй тэмцэх III (2007-2010), Сүү хөтөлбөр (2007-2016), Чацаргана (2010-2016), Хүнсний баталгаат байдал зэрэг хөтөлбөрүүд хэрэгжиж байна
<table>
<tr><th>Хөтөлбөрийн нэр</th><th>2007</th><th>2008</th><th>2009</th><th>2010</th></tr>
<tr><td>Экологийн цэвэр бүтээгдэхүүн</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td></tr>
<tr><td>Иод дутлын эмгэгтэй тэмцэх III</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td></tr>
<tr><td>Сүү хөтөлбөр</td><td>2.021</td><td>30.0</td><td>-</td><td>55.0</td></tr>
<tr><td>Чацаргана хөтөлбөр</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>10,5</td></tr>
<tr><td>Хүнсний баталгаат байдал</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>1.0</td></tr>
</table>
</td>
<td>10</td>
</tr>
<tr>
<td></td>
<td>Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээний бүх хүрээнд эрүүл ахуй, ариун цэврийн зохистой орчин бүрдүүлж хүн амыг аюулгүй хүрэлцээтэй хүнс, тэжээлээр хангах</td>
<td>Хүн амыг тэжээллэг, чанартай, аюулгүй хүнсээр жигд хүртээмжтэй хангасан байна (ШҮ- Хүнсний баталгаат байдал хөтөлбөрийн зорилтын хэрэгжилт)</td>
<td></td>
<td>“Хүнсний баталгаат байдал” хөтөлбөрийг 2010 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</td>
<td>10</td>
</tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***4.2.1.2. Зам тээврийн хөгжлийн бодлого*** | | | | | | | |
| 5.3.8 | Авто тээврийн хэрэгслээс хүрээлэн байгаа орчин, хүн ам, замын хөдөлгөөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг эрс бууруулна. | 1. | Улаанбаатар хот болон томоохон хотуудын тээврийн хэрэгслийг шингэрүүлсэн шатдаг хийн түлшинд шилжүүлэх | Улаанбаатар хот болон томоохон хотуудын тээврийн хэрэгслийг шингэрүүлсэн шатдаг хийн түлшинд шилжсэн байх | Улаанбаатар хот болон томоохон хотуудын тээврийн хэрэгслийг шингэрүүлсэн шатдаг хийн түлшинд бүрэн шилжүүлсэн байх | Хэрэгжиж эхлээгүй байна | 0 |
| ***5.3.5 Хот байгуулалт, барилгын хөгжлийн бодлого*** | | | | | | | |
| 5.3.5.1 | Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог хөгжүүлж, хот суурингийн оршин суугчдад таатай орчин бүрдүүлнэ | 1. | Орон нутгийн хот суурин газруудын инженерийн дэд бүтэц, газар ашиглалтыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу сайжруулах | Инженерийн дэд бүтцийн хөтөлбөрүүдийн биелэлт<br><br>Газар ашиглалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулан орон нутгийн хот суурины тоо | “Ариун цэврийн байгууламжийг сайжруулах хөтөлбөр” “Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах хөтөлбөр”-үүдэд тусгагдсан зорилтуудын биелэлт 50 хувьд хүрсэн байна. | Аймгийн 2010 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2009 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 08 тоот тогтоолоор батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж ажилалаа. Өндөрхаан хотын газар доорхи дулаан, цэвэр, бохирын шугам сүлжээний шинэчлэлийн ажлыг “Боорчи” ХХК нь гүйцэтгэж ,4, 5 дугаар багийн орон сууцны 840 м цэвэр ус, 250 м гадна дулааны шугамын шинэчлэл, 1, 3-р багт 1067 м бохирын шугамыг шинээр хийх ажлыг улс ын төсвийн 371.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгээд байна. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.3.5.4 | Хот суурингийн газар ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгоно | 1. | Газрын мэдээллийн үндэсний системийг бий болгон энэ талаархи мэдээллээр олон нийтэд шуурхай үйлчилдэг болгох | Газрын мэдээллийн үндэсний сиситем бий болсон бий | Газрын мэдээллийн санг бүрдүүлэх мэдээллээр үйлчлэх үйл ажиллагаа жигдэрч тогтвортой болсон байна. | Үндэсний газрын мэдээллийн санг байгуулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нийт 8217 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг нэгдсэн загварт оруулан Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газарт хүргүүлсэн.<br>Мөн уг мэдээллийн санд нэмэлт өөрчлөлтийг хийх шаардлагатай багаж болох 2 долгионы GPS –ийг Монголын Мянганы Сорилтын сангийн Хөрөнгийн эрхийн төслөөс хүлээлгэн өгсөн. | 30 |
| | | 2. | Газрын мониторингийн сүлжээ бий болгож, доройтолд орж эвдэрч, талхлагдсан газрыг нөхөж сэргээж сайжруулах хөтөлбөр, төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэх | Шинээр боловсруулсан бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр<br>Элэгдэл, эвдрэлээс хамгаалсан буюу нөхөн сэргээж сайжруулсан газрын хэмжээ | Газрын элэгдэл, эвдрэлийн зэрэглэл, цөлжилтийн төрөл, ангиллыг тогтоох тэдгээртэй тэмцэх нөхөн сэргээх журмыг боловсруулж батлуулсан байна. | Монгол улсын Засгийн газрын 2010 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 90 тоот тогтоолоор Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсан. Манай газар 2010-2015 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан заалтуудаас ГХБГЗЗГ-ын бодлого, ТА-2 төсөл, Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдтэй хамтран “Орон нутгийн иргэдийн амьжиргааг дээдшлүүлэх зорилгоор газрын боломжит нөөцийн зохистой ашиглалтыг хангаж чадахуйц газар зохион байгуулалтын төлөвлөлтийг шинэчлэн боловсруулах” иргэдийн оролцоотой газар шинэчлэн зохион байгуулах, дахин төлөвлөлтийг хийж гүйцэтгэх ажлыг эхлүүлээд байна. 2010 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу Гашлар, Баянхутаг, Баянмөнх сумдад газар хамгаалах, хөрс сайжруулах, ургамалжуулах, цөлжилттэй тэмцэх нөхөн сэргээлтийг 13.2 га газарт хийв. | 10 |
| ***5.4 Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого*** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.4.1 | Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгож, бүс нутгийн хөгжлийг түргэсгэнэ | 1. | Баруун, Хангайн, Төвийн, Зүүн Улаанбаатарын бүсийн 2015 он хүртлэх хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх | Шинээр боловсруулсан бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр | Баруун бүсийн хөгжлийн төслийг ЗГ-аар батлуулж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлж эхлэх<br>Хангайн, Төвийн, Зүүн бүсийн хөгжлийн төслийг боловсруулж, ЗГ-аар батлуулах, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулна | Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөрийг 2007онд боловсруулан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргасан. 2009 онд Хэнтий аймгийг 2021 он хүртэл хөгжүүлэх цогц бодлого дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулан аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаараа батлуулан хэрэгжүүлж байна. Зүүн бүсийн тулгуур төв хот болохын хувьд Өндөрхаан хотын хөгжлийн дунд хугацааны зорил энэхүү цогц бодлогын хүрээнд хэрэгжих юм. Мөн хөрөнгө оруулалтын дунд хугацааны буюу 2010-2016 оны хөтөлбөрийг гарган жил бүр тодотгол , хяналт хийж холбогдох яамд, Засгийн газарт саналаар хүргүүлж байна. Зүүн бүс нутгийн хөгжилд гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор Хөрөнгө оруулагчдын уулзалт форумыг 2009 оны 8 дугаар сарын 5-6-ны өдрүүдэд Дорнод аймгийн Чойбалсан хотод зохион байгуулсан ба уг уулзалтаар Хэнтий аймгийг зүүн бүс нутгийн аялал жуулчлалын гол бүс нутаг болгон хөгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд аялал жуулчлалын аймгийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж байна. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2. | Бүсийн тулгуур төв болох Ховд, Улиастай, Эрдэнэт, Хархорин, Дархан, Зуунмод, Өндөрхаан, Чойбалсан хотуудын болон аймаг, бичил бүсийн хөгжлийн хөтөлбөрүүд, суурин газруудын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх | Шинээр боловсруулсан бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөр | Бүсийн тулгуур төв Ховд, Улиастай, Эрдэнэт, Хархорин, Дархан, Зуунмод, Өндөрхаан, Чойбалсан хотуудын болон аймаг, бичил бүсийн хөгжлийн хөтөлбөрүүд, суурин газруудын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна | Зүүн бүсийн тулгуур төв Өндөрхаан хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг 2003 онд ЗГ-аар батлуулан мөрдөж байна. Хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлгөөг боловсруулж батлуулахад шаардагдах хөрөнгийн саналыг 2006 оноос эхлэн салбарын болон Сангийн яаманд тавьсан боловч шийдвэрлэгдээгүй байна. Бор-Өндөр хот анх байгуулагдахад хийгдсэн ерөнхий төлөвлөгөөг баримтлан хэрэгжүүлж байна. | 30 |
| ***7.2 Монгол улсын төрийн байгуулал, төрийн удирдлагын хөгжил*** | | | | | | | |
| 7.2.2 | Төрийн удирдлагын шийдвэр гаргах үйл явцын ил тод байдал, түүнд иргэдэд оролцох боломжийг хангана | 1. | Төрийн удирдлагын шийдвэр гаргах үйл явцын ил тод байдал, түүнд иргэд оролцох боломжийг хангах | Төрийн удирдлагын шийдвэр гаргах үйл явцын ил тод байдал, түүнд иргэд оролцох боломжийг хангах эрх зүйн таатай орчин бүрдсэн эсэх | Хэрэгжилтийн үр дүнгээр | Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын гишүүдийн бүрэлдэхүүнд иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан шийдвэр гаргах үйл явцыг иргэдэд ил тод нээлттэй байх боломжийг бий болгосон. Мөн аймгийн үнэлгээний хорооны гишүүдэд иргэний нийгмийн төлөөлөл оролцож хэвшээд байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын ХШҮ-ний ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ТББ-ын төлөөлөгчийг оролцуулан ажиллахаар төлөвлөөд байна. | 30 |
| ***Дундаж оноо*** | | | | | | | 29,4 |

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА А.ГАНТӨМӨР

***<u>Хэнтий аймаг</u>***

**МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГОД ЗААСАН СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, БАЙДАЛ**

/2010 оны эхний хагас жилийн байдлаар/

| | | Бүгд | Эрүүл мэндийн хөгжлийн бодлого | Боловролын хөгжил | Соёлын хөгжил удирдлага | Нийгмийн хамгаалал | Хувийн секторын хөгжил ба жижиг дунд үйлдвэрлэл | Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл | Зам тээврийн хөгжлийн бодлого | Хот байгуулалт, барилгын хөгжлийн бодлого | Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого | Монгол улсын төрийн байгуулал, төрийн удирдлагын хөгжил |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Биелэлт гаргасан | | 53 | 20 | 2 | 2 | 2 | 1 | 19 | 1 | 3 | 2 | 1 |
| Үнээс | 100% | | | | | | | | | | | |
| | Хэрэгжих шатандаа | | | | | | | | | | | |
| | 90% | | | | | | | | | | | |
| | 70% | | | | | | | | | | | |
| | 50% | 12 | 4 | | | | | 8 | | | | |
| | 30% | 29 | 11 | 1 | 2 | 2 | 1 | 7 | | 2 | 2 | 1 |
| | 10% | 9 | 5 | | | | | 3 | | 1 | | |
| Хугацаа болоогүй | | | | | | | | | | | | |
| Тасарсан | | 3 | | 1 | | | | 1 | 1 | | | |
| Биелэлтийн дүн /хувь/ | | 29.4 | 29 | 15 | 30 | 30 | 30 | 33,6 | 0 | 23,3 | 30 | 30 |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ЗДТГ-ЫН ТЗУХ-ИЙН ХШҮ-НИЙ ТАСГИЙН

МЭРГЭЖИЛТЭН Б.БАТТҮВШИН